

“ ХИЧЭЭЛИЙН СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ ” ЯПОНЫ ТОКИО ХОТ ДАХЬ СУРГАЛТЫН ТАЙЛАН МЭДЭЭ

2017 оны 6 дугаар сарын 14-нөөс 21.

Монголын Хичээлийн Судалгааны Нийгэмлэгээс санаачлан зохион байгуулдаг “Хичээлийн судалгааны арга зүйн” ээлжит сургалт 2017 оны 6 дугаар сарын 14-нөөс 21-ны хооронд Япон улсын Токио хотод амжилттай болж өндөрлөлөө.

Сургалтад нийт 15 хүн хамрагдсан бөгөөд их, дээд сургуулийн төлөөлөл, ЕБС-ийн удирдах албан тушаалтан, багш ажилчид хамрагдлаа.

Үйл ажиллагааны хүрээнд Японы боловсролын системтэй танилцаж, Японы бага болон дунд, их сургуулийн харьяа лицей сургуулийн үйл ажиллагаа, сургалтын процесс зэрэгтэй танилцаж багш нартай харилцан туршлага солилцлоо.

Сургалтын хугацаа 7 хоног байсан бөгөөд өдөр бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг тоймлон харууллаа:

Хүснэгт1. Үйл ажиллагааны тойм төлөвлөгөө

№	Үйл ажиллагаатай танилцсан сургууль	Он, сар, өдөр
1	Японы боловсролын музей	2017.06.15
2	Цэцэрлэгтэй танилцах	2017.06.15
3	Конан дунд сургууль	2017.06.16
4	Онаримон бага сургууль	2017.06.19
5	Минато дүүргийн боловсролын газар	2017.06.19
6	Сэтагаяа бага сургууль	2017.06.20
7	Хичээлийн судалгаа, үнэлгээ лекц	2017.06.21

Сургууль бүрээр зочилсон дэлгэнгүй тайланг хавсралтаас үзнэ үү.

Хавсралт1. Японы боловсролын музей

СӨБ-ийн үйл ажиллагааны тухай

Хавсралт2. Конан дунд сургуулийн тухай

Хавсралт3. Онаримон бага сургуулийн тухай

Минато дүүргийн боловсролын газартай уулзсан уулзалт

Хавсралт4. Сэтагаяа бага сургуулийн тухай

Хичээлийн судалгаа, үнэлгээ лекцын тухай

БОЛОВСРОЛЫН МУЗЕЙ

Япон улсын Боловсролын яам 4 салбарыг нэгтгэж, БСШУС-ын яам болсон. Боловсролын музей 2001 оноос байгуулагдсан. Одоогийн энэ байр нь 1933 оноос 2001 он хүртэл тухайн үеийн Боловсролын яам байрлаж байсан ба 2001 оноос тухайн яамтай чиг үүргийн хувьд ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг салбарууд нэгдэж, шинэ байранд шилжсэнээр түүхэн үеийг харуулсан “БОЛОВСРОЛЫН МУЗЕЙ” бий болсон.



1600 онд анх боловсрол бий болж, гэрийн сургууль эхэлж байсан. Тухайн үе нь Межигийн үе байсан ба самуурайнууд хичээл заалгаж байсан. Тэр үеэс бүх нийтээр боловсрол олгож,



дуу хөгжим зааж эхэлсэн. Шовагийн үед \дайны үе\ 1912 оноос эхэлж, хоол хүнс ховор байх тэр үед сургууль үдийн хоол өгч байсан. 1920 оноос бага ангиас дунд сургууль руу шилжсэн. Шовагийн 1920 онд анхны сурах бичиг батлагдан гарсан. 1933 оноос Боловсролын анхны сайд Мури Ари Нури сан ажиллаж байсан ажлын өрөөг тэр хэвээр нь хадгалан үлджээ.

Музей нь 4 салбарын түүхэн амжилтуудыг харуулсан өрөөнүүдтэй.

1. Боловсрол
2. Спорт
3. Шинжлэх ухаан
4. Мэдээлэл, технологи

5. Түүх, соёл

БОЛОВСРОЛЫН ХОРОО

Минато дүүргийн Боловсролын хорооны дарга Аоки, ахлах мэргэжилтэн Кубаяши, бага боловсрол хариуцсан мэргэжилтэн Озаки Науми, арга зүйчдийн ахлах зөвлөх Пацудима, ТББ-ын сургууль завсардалтыг хариуцсан мэргэжилтэн КаДэ Бэй нартай уулзлаа. Боловсролын хорооны дарга хэлэхдээ:

Минато дүүргийн сургуулийн боловсролын зорилго нь:

1. Сайхан сэтгэл, эрдэм мэдлэг, эрүүл биеийг төлөвшүүлдэг сургууль
2. Аливааг даван туулах чадвартай хүүхэд болгон төлөвшүүлэх
3. Нийгэм, орон нутгийн дэмжлэг авах
4. Сургалтын орчинг сайжруулна гэсэн үндсэн 4 зорилтын хүрээнд 2015-2020 он хүртэлх төлөвлөгөө гарган, хэрэгжүүлэн ажиллаж байна. Боловсролын хорооны дарга Аоки хэлсэн үгэндээ: Чиг үүргээрээ боловсрол соёл, тусгай хэрэгцээт боловсролыг хариуцдаг. 2 жилийн өмнөөс манай дүүрэг МХСН-тэй хамтран ажиллаж эхэлсэн. Энэ цаг үед боловсролын шинэчилсэн хөтөлбөр гарч байгаатай уялдуулан ирэх хичээлээс жилээс багш нарт сургалт зохион байгуулах бэлтгэл ажил хангаж байна. Өмнөх стандарт мэдлэгийг голлосон ба одоогийн стандартад агуулгыг багасгасан. Дэлхий нийтээр мэдлэгийг хэрэглээ болгох тал дээр анхаарч байгаатай уялдуулан, дэлхийн PSA үнэлгээгээр японы боловсролд үнэлгээ хийхэд хүүхдийн мэдлэг бүтээх чадвар дутмаг гэж үнэлэгдсэн. Иймд шинэчлэгдэн стандартад хүүхдийг амьдрах ухаанд сургах, мэдлэгийг өөрөө бүтээх бодит үйл ажиллагаагаар дамжуулан хөгжүүлэх талаар илүү их тусгасан. Мөн СӨБ болон бага, дунд, ахлах сургуулийн



залгамж холбоог сайжруулах



КООНАН ДУНД СУРГУУЛЬ

2017 оны 06 дугаар сарын 16-ны өдөр сургалтад хамрагдсан 15 багш дараах үйл ажиллагаанд оролцов. Үүнд:




✚ Минато дүүргийн Коонан дунд сургуультай танилцсан

✚ Минато дүүргийн Коонан дунд сургуульд зочилсон тухайд эргэн харах Q&A

✚ NPO АББ “Минато хичээл бүтээх академи” үйл ажиллагаатай танилцах

Минато дүүргийн Коонан дунд сургууль тухай

Минато дүүргийн Коонан дунд сургуулийн захирал Ватанабэ Казүнобү, дэд захирлын хамтраар биднийг хүлээн авч уулзсан. Уулзалтын үеэр сургуулийн менежмент төлөвлөгөө, сургуулийн боловсролын зорилго, сургалтын өдөр тутмын үйл ажиллагаа зэрэг сургуулийн танилцуулгаа хийсэн.



Биднийг сургуульд зочилоход сурагчид монголоор “Сайн байна уу” хэмээн мэндчилж байсан бөгөөд бидэнд зориулан сурагчдад зааж өгсөн байв.

Тус сургуулийн захирал Ватанабэ Казүнобү хэрхэн сургуулийн захирлын ажлыг хийж байгаа болон сургууль анх үүсгэн байгуулагдсан, өнөөгийн түвшинд хэрхэн хүрсэн тухайгаа дэлгэцийн үзүүлэнгээр танилцуулав. Токио Кайёо их сургуультай хамтран сургууль байгуулагдах үеийн Шибаүра махны захын ойролцоох орчны болон Унгани голын Шибаүра I land кани даланг хэрхэн хаягдал төмрийн карбидыг ашиглан цэвэршүүлэх судалгааны төсөл хэрэгжүүлсэн тухай танилцуулав.

Сурагчдын үдийн хоолны танилцуулга ямар байдаг, орц норм, олон үндэстэн, гарал үүслийн олон янз орцтой хоол, эцэг эхийн зөвшөөрөл, хоолны мөнгийг хэрхэн бүрдүүлдэг тухай танилцуулав. Хоолны дээжээс монгол багш нарт амсуулав.



Сурагчдын асуудлаар

- Орон нутагт дахин хөгжүүлэх
- Нийгмийн хувьд хуучин төвлөрсөн оршин суугчид ба шинээр ирэх оршин суугчдын хоорондын ойлголцол, харицааны ялгааг арилгах

Жижиг дунд сургуулийн хувьд

- Сургуулийг бусад ижил дунд сургуулийн түвшинд аваачих
- Тус сургуульд сурдаг сурагчдыг өөрийгөө батлах мэдрэмжтэй болгох
- Сургуулийн хэмжээ жижгэрч байгаа
- Сурагчид хамрагдах дүүргээс гадна байгаа

Сургуулийн шинэчлэл

- Зорилтот сурагчдын тоог нэмэгдүүлэх
- Сургалтын зорилтыг шинэ шатанд гаргах
- Сурагчдын формын загварыг шинэчлэх
- Орон нутгийн холбоонд оролцох
- Нутгийн иргэдтэй хамтран ажиллах

Коонан төсөл

- Бүх багш нар Коонан стандартаар хичээлээ явуулах
 - Суралцагчдын дүрмийг боловсронгуй болгох
 - Суралцах үеийн 5 амлалт авахуулах

- Сурагчид өдөр өдрийн хичээлийг шалгах
- **Коонан дэвтэр**
 - 7 хоног бүр багш дэвтрийг шалгаж урамшууллын наалт наах
 - Зүрх сэтгэлийн боловсрол
 - Нөхөн үржхүйн боловсролыг анхаарах
 - Өөрийн дотоод шинэ хүнтэйгээ танилцах
- **Гурван багана**
 - Юу мэдэж байна
 - Юу чадаж байна
 - Мэддэг чаддаг зүйлээ яаж хэрэглэх вэ?

“Өөрийн онцлог бүхий сургалтын хэрэгцээ” гэсэн сэдвүүдээр боловсролын салбарын чухал гарцыг хайх тухай харилцан ярилцалга хийлээ.



(Биеийн тамрын хичээлийн үеэр)

Сурагчдыг сайн мэдлэгтэй, дундаж, удаан ойлголттой гэж 3 ангилан сургалтыг явуулдаг ажээ.



Удаан ойлголттой сурагчдад 2-3 багш тулж ажилладаг байна.



Тэдэнд зориулан анги танхим, коридорыг тусгайлан тоногложээ.

ОНАРИМОН БАГА СУРГУУЛЬ

9.00 цагт Минота дүүргийн Онаримон бага сургуульд очиход сургуулийн захирал Вада Кёоко хүлээн авч сургуулийн танилцуулга, мэндчилгээ хийлээ. Энэ өглөө тус сургуулийн багш нарын хурал дээр Монголын зочид ирэх талаар мэдээлж Монгол улс Орос, Хятад 2 улсын дунд байрладаг, 2-р ангийн сурах бичигт “Цагаан морь” өгүүллэг орсон байдаг, нийт сурагчдад “Сайн байна уу” гэж монгол мэндчилгээ заагаарай гэх мэтээр танилцуулсан талаар захирал ярих.

Онаримон бага сургуулийн эрхэм зорилго нь: “Сайтар тунгаан бодож, өөрөө суралцдаг, тунгаан бодож үйлдлээ хийдэг, ирээдүйгээ бүтээх хүүхэд” гэж тодорхойлжээ. Энэхүү зорилгыг биелүүлэх үндсэн чиглэл нь

- Хүнийг хүндлэх сэтгэлтэй, зөв хандлага төлөвшсөн хүүхэд болгон төлөвшүүлэх
- Үндсэн суурь мэдлэг олгохын зэрэгцээ хүүхэд нэг бүрийн хэрэгцээнд нийцсэн баттай мэдлэг, чадварыг төлөвшүүлнэ.
- Хүсэл сонирхолтой байх, аливааг дуустал хийх зан чанарыг төлөвшүүлнэ.
- Харилцааны чадварыг төлөвшүүлнэ.
- Эрүүл мэнд, аюулгүй амьдрал, бие бялдарын хөгжлийг байнга дээшлүүлнэ.
- Хүүхдийн хүмүүжүүлэхэд эцэг эх, асран хамгаалагч, орон нутгийн нэгдмэл үйл ажиллагааг чиглүүлнэ тодорхойлсон байна.


9.30 цагаас 4-р ангийн математикийн хичээлд ажиглалт хийв.

2 бүлгийн сурагчдыг нийлүүлж математик сэтгэлгээ, сэтгэхүйн хурд, суралцах чадвараар 3 групп болгон хувааж сургалтыг зохион байгууллаа. Энэ нь тухайн хүүхдийн түвшинд тохирсон арга зүйгээр боловсрол олгох, хүүхэд бүртээ тулж ажиллах зорилготой гэнэ.

1- р групп суралцах хурд сайтай түвшний сурагчдад математикийн мэргэжлийн багш





2- р групп дундаж болон 3-р групп хурд удаан, дэмжлэг шаардлагатай түвшний



сурагчдад даасан ангийн багш нар нь хичээлийг хөтлөн явууллаа.

Групп бүрт “Перпендикуляр шулуун” сэдэвт хичээлийг “ өөр арга зүйгээр хөтлөн явуулж байгаа нь онцлог, санаа авахуйц байлаа. I түвшний сурагчдад амьдралын бодит хэрэгцээнд тулгуурласан асуудлыг шийдвэрлэх таамаглал дэвшүүлж, шинжлэн судалж, олон талаас нь харж бие даан мэдлэг бүтээх, II түвшний сурагчдад багшийн дэмжлэг, чиглүүлэгтэйгээр дагуулж гүйцэтгэх, техник хэрэгсэл ашиглан харуулах, турших замаар



мэдлэг бүтээх, III түвшний сурагчдад хэрхэн хийх аргыг нэг бүрчлэн хэлж өгөх, багшийн дэмжлэгтэйгээр дасгал даалгаврыг гүйцэтгэх арга зүйгээр хичээлийг хөтлөн явуулж байлаа. Эндээс хичээлд ажиглалт хийх явцдаа сурагчдын ялгаатай байдлыг тооцож сургалтыг зохион байгуулах нь сэдэв, агуулга биш хөтлөн явуулж байгаа арга зүйгээрээ ялгаатай юм байна гэсэн дүгнэлтэд хүрлээ. Өөрөөр хэлбэл сурагчдын хувьд ижил зүйлийг өөрийн онцлогт тохирсон өөр өөр арга замаар мэдэж, сурна гэж ойлгож болно.

Тус сургууль 2-р ангиас эхлэн бүх ангиудад зөвхөн математикийн хичээлээр тухайн ангийн нийт сурагчдыг нэгтгэн бүлэг сэдэв бүрийн дараа шалгалт авч, ялгаатай 3 түвшинд хувааж сургалтыг зохион байгуулдаг байна. Шалгалтаар сурагчдыг түвшинд хуваахдаа шалгалтын дүнг тооцохоос гадна “би муу юм байна” гэх мэтээр сурагчдын сэтгэл зүйд нөлөөлөхгүй байхаар саналыг нь харгалзах хэрэгтэйг сануулж байлаа.

Тусгай хэрэгцээт боловсрол (Хэл засал, сонсголын хичээл)



Хараа, сонсгол, хэл ярианы болон бусад төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд боловсрол олгоход дэмжлэг үзүүлэхүйц бүх талын шаардлага хангасан кабинетуудыг иж бүрнээр тохижуулсан бөгөөд тэнд ойролцоох сургуулиудаас тусгай хэрэгцээт сурагчид ирж 7 хоногт 1-2 цагаар ганцаарчилсан болон анги, бүлэг үүсгэн өөрт тохирсон онцлог бүхий сургалтанд хамрагдаж, бусад үед өөр өөрийн сургууль дээрээ ердийн хөтөлбөрөөр ангийнхантайгаа хичээллэдэг байна. Сургалтыг мэргэжлийн багш нар явуулдаг нь үр дүнтэй санагдлаа. Ихэнх сургалт ганцаарчилсан байдлаар явагддаг, 1-5 сурагчтай бүлгээр хичээлэх тохиолдол байдаг, 5 багш 5 тусдаа өрөөнд хичээллэдэг.



Биеийн тамирын хичээл

Сургуулийн дээвэр дээр усан бассейнтай, зуны улиралд сэлэлт, чийрэгжүүлэлтийн хичээл явагддаг. Нэг ээлжинд 4 бүлгийн сурагчид хичээллэдэг, өмссөн хувцасаараа ялгагддаг. Нэг багш ерөнхий удирдаж зааварладаг, бусад багш нар нь аюулгүй байдал, эрсдэлээс хамгаалах, хяналт тавих зэргээр тусладаг. Нэг удаад 2 цагаар хичээллэдэг эхний цагт бие халаалт, аюулгүй ажиллагааны санамж, эрүүл мэндийн үзлэг, шүршүүрт орох үйл ажиллагаа хийгдэнэ. Эрүүл мэндийн үзлэгээр халуунтай, ханиадтай бол хичээлээс чөлөөлөгддөг. Мөн нарны харшилтай сурагчдад битүү хувцас өмсөхийг зөвшөөрдөг.

Бассейны ус солих, цэвэршүүлэх, халдвараас сэргийлэх эрүүл ахуйн нөхцөлийг бүрэн



хангаж ажилладаг байна.



Номын сангийн үйл ажиллагаатай танилцав.

Номын санч

- Номын сангийн орчинг сайжруулах
- Шинэ номыг сурагчдад танилцуулах
- Багш нарын захиалгаар тухайн цагийн хичээлд шаардлагатай номуудыг бэлтгэн хүргэж өгөх
- Тухайн цаг үе, улиралтай (Жишээ нь: Борооны улиралд ямар ямар үзэгдлүүд явагддаг вэ? Мэлхий

олширдог, мэлхийн тухай гэх мэт) холбоотой номуудыг фондноос гаргаж үзэсгэлэн сурталчилгаа хийх гэх мэт үндсэн ажлаас гадна олон зүйлийг санаачилж хийдэг.



Их завсарлагаа ба үдийн хоолны цаг

Их завсарлагаа ба хоолны цаг 11 цагаас 45 минутын хугацаанд үргэлжилдэг (20 минут хооллох, 20 минут гадаа тоглох, 5 минут дараагийн хичээлд бэлтгэж орох).



Тусгайлан хоол зүйч мэргэжилтэн ажилладаг. Тухайн сарын өдөр бүрээр нь хоолны нэр, орц, илчлэг, эрүүл мэндийн талаас ямар ач холбогдолтой гэх мэт мэдээллүүдийг багтаасан хоолны цэсийг урьдчилан гаргаж эцэг эхчүүдэд хүргэдэг.

Хоолны цэс хэвлэсэн арын нүүрэнд хэдэн настай хүүхэд ямар хоол хүнс хэрэглэх, зарим хоолны жор, эрүүл, зөв



хооллолтын талаар мэдээлэл, зөвлөлгөөг оруулж өгдөг.



Эцэг эхчүүд цэстэй

танилцаад хүүхдэдээ харшлах ямар нэг орц байвал хэлж тухайн өдрийн хоолыг өөрчлүүлэх боломжтой юм байна.

Хоолны мөнгийг гэр бүлээс нь төлдөг. Эрүүл, шинэ, амин дэмтэй, хамгийн сайн чанарын зөв хоол хүнсээр хангахыг сургууль хариуцдаг. Мөн багш сурагчидтайгаа хамт хооллодог, хоолыг ангийн жижүүр сурагчид савлаж өгдөг, хоол үлдээхгүй идэх, аяга, тавгаа эмх цэгцтэй хураах гэх мэт олон сайн хэвшил санаа авах зүйлүүд байна.

Чөлөөт завсарлагаа




Ерөнхий ажигласан, хэрэгжүүлж болох санаанууд, онцлог зүйлс

- Самбар ашиглалт (Тухайн цагийн зорилго, зорилт, өнгийн шохой ашиглан бичиж тэмдэглэж байгаа байдал)
- Үйлчлэгч байхгүй цэвэрлэгээг сурагчид өөрсдөө хийдэг (Цэвэрлэгээний алчуур бүр нэртэй). Эндээс цэвэрч байх дадал хэвшилтэй болохоос гадна багаасаа ажил хийж



сурах юм байна гэсэн сэтгэгдэл төрсөн.

- Анги танхим, сургуулийн орчин, тохижилт



Багш нарын өрөө



Зарим кабинетууд

- Техник хэрэгсэлийн хангамж, оновчтой ашиглаж байгаа байдал (Document camera)





- Сургуулийн орчинд хяналтын камер байхгүй шаардлагатай бол зарим нэг сургууль үүдэндээ байрлуулах тохиолдол байдаг. Бусад чөлөөт цагаар тоглох, хичээллэх орчинг захирал, багш нар өөрөө явж хяналт тавьдаг.

- Анги бүр малгай гэх мэт хувцасаараа жигдэрч ялгардаг нь үеийн хүүхдүүд хоорондоо дотносох, ахлах ангийнхан дүү нартай туслах боломж олгодог. Энэ нь бас нэг төрлийн соёл, боловсролыг олгож байгаа нь таалагдлаа.



- Хэт мэдрэг, элдэв дуу чимээнд дургүй хүүхдүүдэд зориулж сандал ширээний хөлийг хамгаалсан байдал

- Анги танхимын хана, хаалгыг шийдсэн байдал, мэдээллийн самбар гэх мэт олон



санаа авах шийдлүүд байна.



Минота дүүргийн боловсролын газар



Дүүргийн боловсролын газар нь чиг үүргийн хувьд Монголынхтай төстэй байлаа.

Дүүргийн боловсролын газрын дарга биднийг хүлээн авч дараах зүйлүүдийг ярьсан.

-Сургуулийн өмнөх боловсрол, бага, дунд, ахлах сургуулиуд, тусгай хэрэгцээт боловсрол, спортын байгууллагыг хариуцаж ажилладаг.

- 2 жилийн өмнөөс Монголтой харилцаатай болсон.

- Манай жишиг дүүргийн зарим сургуулиудын үйл ажиллагаатай танилцаад өөрийн сургууль, байгууллагадаа хэрэгжүүлэх санааг хэрэгжүүлж үр дүнд хүрвэл бид баярлах болно. Цаашид хамтран ажиллахад нээлтэй байх болно. Мөн манай сургуулиудаас тусгаж

авах ямар зүйлүүд байв, мөн эргэлзээтэй санал нэгдэхгүй зүйл байвал хэлж ярьвал хамтран суралцах, тусгаж авах зүйл гарах байхаа гэсний дагуу бид санал бодлоо солилцож ярилцлаа.

Мөн нийслэлээс томилогдон ажиллаж байгаа мэргэжилтэн Японы боловсролын салбарын талаар товч танилцуулга хийж, бидний сонирхсон асуултад хариулав.



СЭТАГАЯА БАГА СУРГУУЛЬ

Токио хотын Гакугэй их сургуулийн түшиц Сэтагаяа бага сургууль нь 1876 онд байгуулагдсан 142 жил тасралтгүй сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа түүхэн сургуулийн нэг байлаа. 27 багш, 630 хүүхэдтэй. Хүүхдэд боловсрол олгохоос гадна Япон улсын сайн багш нарыг бэлтгэн гаргах зорилгын доор үйл ажиллагаа чиглүүлэн туршилт судалгааны дүнд боловсруулагдан гарсан хөтөлбөрийг хэрэгжүүлдэгээрээ онцлогтой. Тус сургууль нь хамтын хөдөлмөрөөр хамгийн бүтээлч үйл ажиллагаа, үйлчилгээг үзүүлдэг.

Хичээлээс гадуурх үйл ажиллагааны хөтөлбөрийг хүүхдүүд өөрсдөө төлөвлөн гаргадаг, түүнийгээ хэрэгжүүлэхэд нь багш нар нь зөвлөн тусалж ажилладаг. Гакугэй их сургуулийн багш ангийн оюутнууд 3,4-р курсдээ тус сургуульд 3 удаа багшлах дадлага ажлыг хийдэг, ажиглалт судалгааг явуулдаг.



Биднийг 2 группэд хуваариан Эжиго багш, Курихара дэд захирал нар замчлан Математик, байгалийн ухааны хичээлүүд дээр ажиглалт хийлээ. 1-3-р ангид анги удирдсан багш нар, 4-6-р ангид байгалийн ухааны мэргэжлийн багш нар хичээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэн чиглүүлж ажилладаг. Энэ үеэр Гакугэй их сургуулийн оюутнууд тус сургууль дээр ажиглалт судалгаа явуулж байсан. 4-р ангийн 32 хүүхдэд хэрэгжүүлсэн байгалийн ухааны хичээлийн тухайд:

- Сургуулийн орчинд судалгаа хийх боломжтой байгалийн ойн тогтоцыг харуулсан талбайтай. Хүүхдүүд гаднах орчны тарьсан ургамал, байгалийн зургийг ICT-табаар авсан байсан. Энэ зурган мэдээлэлдээ үндэслэн Япон хэлний 5 үсэг, 7 авиа бүхий ханзтай үгээр тайлбарыг илэрхийлүүлсэн.
- Тайлбарыг хүүхдээр хэлүүлэхдээ самбарт тухайн хүүхдийн таб дахь зургийг проектороор гарган тайлбарлуулсан. Жнь: Чулуун дээр зогсоо сонын зургийг авсан хүүхэд ийм халуун өдөр соно чулуун дээр суугаад усанд сэлэхийг бодож байгаа байх даа, мөн бас нэг хүүхэд модны сүүдэр дэхь сандал дээр унасан навчны зургийг хараад сандал дээр тавьсан навнчууд ямар жаргалтай байна вэ, сүүдэрт амарч

байгаа байх даа гэх мэтээр өөрсдийн бодсоныг чөлөөтэй илэрхийлж байсан. Амьд байгалийг өөрийн санаагаар, өөрийн үгээр тайлбарласан.

- 3 хүүхдийн тайлбарыг сонсоод багш өөрөө нэгтгэх дүгнэлтийг хэлэлцүүлсэн. Энэ үед багш хүүхэд нэг бүр дээр очиж тайлбарлаж ярилцсанаас гадна нэг хүүхдэд хэлсэн тайлбараа бусад хүүхдэд тодоор мэдээлэн хэлж байсан.

5-р ангид хэрэгжүүлсэн байгалийн ухааны хичээл, байгалийн ухааны туршилт хийдэг кабинетыг байгалийн ухааны багш Ори багш танилцууллаа.

- Тухайн хичээлийн туршилт явагдаж дууссан байсан. Иймд самбарын бичиглэлээс бүх тайлбарыг хийсэн. “Урсаж байгаа ус нь ямар нөхцлөөс болон өөрчлөгддөг” гэсэн асуудлыг



туршилтаар шийдвэрлэсэн. Туршилтыг сургуулийн гаднах талбайд хийсэн байсан. Элсийг худалдан авч модон тавцангаар газрын гадаргыг төлөөлүүлэн дээр нь элсээ асган, тодорхой өнцгөөр байрлуулан, ус тухайн элсээр хэрхэн урсахыг туршсан. Эндээс А,В,С гэсэн 3 туршилтыг хийсэн. “А” туршилтаар 0.5л усыг 45 градусаас бага өнцгөөр байрлуулсан элс бүхий гадаргуугаар, “В” туршилтаар 2л усыг буюу их хэмжээний усыг дээрхэй адил гадаргуугаар, “С” туршилтаар 0.5л усыг эгц байрлуулсан гадаргуугаар урсгаж дараах дүгнэлтүүдийг хийсэн байсан.

Дүгнэлт: Ахуйн хэрэглээтэй холбоотой дүгнэлтийг гаргуулснаараа онцлогтой.

- ✓ Гамшгийн үед ямар газарт байрлахыг, тбал: их бороо ороод үер үүсвэл би ямар газар очих вэ өөрөөр хэлбэл эгц гадаргуутай газрын уулын ойр орчимд байж болохгүй, өндөр уулын хажууд гэрээ барьж болохгүй хүүхэд ойлгож авахыг энэ хичээлээс шийддэг.
- Мөн байгалийн ухааны кабинетэд зуухны шаталтыг яндангаар яаж дэмжиж явуулдагийг туршсан байсан. Кабинет дахь хэрэглэгдэхүүнийг хүүхдэд хэрхэн хэрэглэх, алийг нь сонгож туршилтыг хийхийг тайлбарладаггүй хүүхэд өөрсдөө сонгож туршитыг явуулдагаараа онцлогтой.

- Блокыг өөрсдөө өрж пийшин барьж түүндээ бэлтгэсэн модноос хийн шатаах туршилтыг явуулсан. Энэ үед агаарыг багасгаж, ихэсгэж өгөх байдлаар /яндангийн дээд хэсгийг таглах, нээх байдлаар/ шаталтыг хэрхэн явуулахыг, орчны температур хэрхэн өөрчлөгдөж байгааг термометрээр хэмжих зэргийг туршсан. Хүүхдүүд туршилтыг чөлөөтэй бодож, сэтгэн хийнэ. Блок нь багадсан тул нэмэх хэрэгтэйг хэлэлцэж байгаад туршилтыг дуусгалгүй явсан тул үргэлжлүүлэн туршилтыг хийнэ.

Математикийн хичээлийн тухайд: 3-р ангийн хуваах үйлдлийн, 5-р ангийн энгийн бутархайн хуваах үйлдэл гэсэн сэдвүүдийн эхний цагийн хичээлүүдийг сурагч төвтэйгээр зохион байгуулж буй хичээлүүдийг үзэж сонирхлоо.

- Эдгээр хичээлүүдийн арга зүйн онцлог гэвэл хэрхэн шийдэж болох аргуудыг зөвхөн хүүхдээр өөрсдөөр нь гаргуулан багш түүнийг нь самбарт тэмдэглэн дүгнэлтийг гаргуулж нэгтгэж өгч байсан. Математикийн хичээлд өнгийн шохойг өргөн хэрэглэж, самбар төлөвлөлтийг хүүхэд бүрийн санааг тусган гайхамшигтай хийж байгааг монгол багш бүр тусган хэрэгжүүлэх хэрэгтэй гэж бодлоо.
- Математикийн хичээл дээр сурагчдын өмнөх мэдлэг чадварт тулгуурлан төвшингөөр ангилан ээлжит хичээлийг зохион байгуулж байгаа онцлог байна. Энэ нь хүүхдийн ялгаатай байдлыг харгалзан үзэж байгаагийн тод илрэл байна. Хүүхдийг ингэж төвшингөөр ангилахдаа ихээхэн болгоомжтой ханддаг. Жишээ нь: Хамгийн доод төвшинд хамрагдсан хүүхэдтэй ярилцаж сэтгэгдлийг нь сонсдог гэх мэт.

Үдээс хойш: “Байгалийн шинжлэлийн хичээлийн бэлтгэл судалгаа ба байгалийн шинжлэлийн хичээлийн сургалтыг дэмжих сургуулийн орчны менежмент” Токио хотын Кита дүүргийн Такиногава бага сургуулийн захирал, Очаномизү эмэгтэйчүүдийн ИС-ийн ШУ ба боловсролын төвийн зочин профессор Хаяаши Широ танилцууллаа.

“Багшийн хичээлийг удирдах менежментийн чадвар”

- А. Хичээлийн бэлтгэл судалгаа-хүүхдүүд ба сургалтын материал хоорондын холбоо хамаарлыг авч үзэх
- Б. Хүүхдийн талаарх ойлголт-бодит байдлыг тодорхойлох
- В. Сургалтын материалын талаарх ойлголт –агуулга
- Г. Дээрх судалгааны үр дүнд гарсан хөтөлбөрийг хүүхдэд зааж хэрэгжүүлэх

оны сүүл, 2019 оны эхээр стандарт шинэчлэгдэх тул шинэчлэх хувилбарыг 2 жилийн өмнөөс туршин хэрэгжүүлж байна. Мэдлэг чадварын 3 бүрэлдэхүүнийг тодорхойлсон.

1. Суурь үндсэн мэдлэг чадварыг эзэмшүүлэх
2. Мэдлэг чадварыг ашиглаж, асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай сэтгэн бодох чадвар, шийдвэрлэх чадвар, илэрхийлэх чадварыг хөгжүүлэх
3. Сурах идэвх сонирхлыг нэмэгдүүлэх

Аливаа улсын боловсрол байгалийн шинжлэл, математикийн боловсролыг чанаржуулахыг зоридог.

- Агуулгын залгамж холбоо ШУ-ы ухагдахуун ШУ-нчаар сэтгэн бодох чадвар Хичээл судалгаа Бүтээл бүтээх
- Хүүхдийг идэвхтэй оролцож суралцах аргыг нэвтрүүлэх, хэрэгжүүлэх

Асуудлыг дэвшүүлэн түүнийг шийдвэрлэх аргаар мэдлэг бүтээгдэх хэлбэрийн хичээлийг зохион байгуулдаг. Явц:

1. Байгалийн бодит байдал ба үзэгдэл тохиох
2. Асуудлыг тодорхойлох
3. Төсөөлөл, таамаглал дэвшүүлэх
4. Ажиглалт туршилт хийх
5. Үр дүн гарах
6. Дүгнэлт хийх
7. Хэрэглэх гүнзгийрүүлэх

Цаашид хэрэгжүүлэх санаа:

- Үдийн цай хөтөлбөрт Япон улсын үдийн хоолны туршлага соёлыг нэвтрүүлэх
- Сургууль доторх орчны цэвэрлэгээг 1,2-р ангийн суралцагчдаас эхлүүлэх
- Бага ангиас дунд ангид шилжин орж байгаа суралцагчдыг хооронд нь хольж хичээллүүлэх
- Эцэг эх, орон нутаг, сургуулийн хамтын ажиллагаагаар дамжуулан орчны менежментийг сайжруулах